

**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ-ЫН  
АЛБАН БИЧИГ ШИЙДВЭРЛЭЛТИЙН МЭДЭЭ  
/2020.01.22-2020.12.22/**

2020 оны 12 дугаар сарын 22-ны өдөр

Багануур дүүрэг

“Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-т 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар нийт 207 албан бичиг ирснээс, хариутай бичиг 84, хариугүй бичиг 123 байгаагаас Удирдлагад 8, Захиргааны албанд 118, Үйлдвэрлэл, технологийн албанд 81 хуваарилагдан тус тус шийдвэрлэгдсэн. Мэргэжилтнүүд хариуцсан үйл ажиллагааны чиглэлээр өөрсөддөө хуваарилагдсан албан бичгээ түргэн шуурхай, чанартай шийдвэрлэж байна.

Албан бичгийн эхийг eDoc программаар боловсруулж хэвшсэн. Албан бичгийн шийдвэрлэлтэд eDoc программын модулиудыг бүрэн ашиглахыг зорьж байна. Хариутай бичгийн шийдвэрлэлт 98,89 хариугүй бичгийн шийдвэрлэлт 100%-тай, нийт ирсэн бичгийн шийдвэрлэлт 99,02%-тай, 1 хариутай бичиг судлагдах шатандаа явж байна.

Нийслэлийн Архивын газраас өгсөн чиглэлийн дагуу, Э-токен төхөөрөмж авахад шаардлагатай бичиг баримтуудыг зааврын дагуу бүрдүүлж Газрын дарга болон Бичиг хэрэг, архив, гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн нар Үндэсний Дата төвийн баталгаажуулсан 2 тоон гарын үсгийн гэрчилгээг хүлээн авч үйл ажиллагаанд ашиглаж жигдэрсэн.

Санхүүгийн үйл ажиллагаанд тоон гарын үсэг ашиглах шаардлагын улмаас Нягтлан бодогчид тоон гарын үсгийн гэрчилгээ авах хүсэлтийг 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 225 дугаартай албан бичгээр Үндэсний Дата төвд хүргүүлээд байна.

Манай байгууллагаас 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар харилцан холбоотой ажилладаг яам, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газар, аж ахуйн нэгж, албан байгууллагуудад нийт 244 албан бичиг явуулсан байна.

Албан бичгийн шийдвэрлэлтийн байдлыг графикаар харуулав.

**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ-ЫН  
АЛБАН БИЧГИЙН ШИЙДВЭРЛЭЛТ**

/2020 оны жилийн эцсийн байдлаар/



“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ-ЫН  
АЛБАН БИЧГИЙН ШИЙДВЭРЛЭЛТ

/2020 оны жилийн эцсийн байдлаар, тоон үзүүлэлтээр/

№	Нийт ирсэн бичиг	Хариутай бичгийн тоо	Хариугүй бичгийн тоо	Шийдвэрлэлтийн дундаж хугацаа/хоног	Явуулсан бичиг
1-р улирал	61	21	40	3.75	55
2-р улирал	52	25	47	2.44	71
3-р улирал	39	15	24	3.38	59
4-р улирал	55	23	32	2.55	59
<b>Жилд, нийт</b>	<b>207</b>	<b>84</b>	<b>113</b>	<b>3.02</b>	<b>244</b>

Албан бичгийг хамгийн боломжит богино хугацаанд, чанартай шийдвэрлэхийг зорьж байгаа бөгөөд хариутай бичгийн шийдвэрлэлтийн дундаж хугацаа 2.44-3.38 хоног байна. Албан бичгийн шийдвэрлэлтийн зөрчил дутагдал, хугацаа хэтэрч хаагдаагүй болон хугацаа хэтэрч хаагдсан албан бичиг байхгүй.

ХЯНАСАН:  
“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК”  
ОНӨТҮГ-ЫН ДАРГА



Ч.ЭЛБЭГСАЙХАН

ТАЙЛАН ГАРГАСАН:  
БИЧИГ ХЭРЭГ, АРХИВ, ГАДААД  
ХАРИЛЦАА ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН *M. Munkhulam* М.МӨНХДУЛАМ